

# СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.29 №44 (44)

ҮЙЛ ЯВДАЛ



## ХИЛ БОЛОН ДОТООДЫН ЦЭРЭГТ ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫГ ТАТАХГҮЙ

Засгийн газрын энэ сарын 28-ны өдрийн ээлжит хуралдаанаар Монгол Улсад үүсээд буй цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 оны нэгдүгээр ээлжээр Хилийн болон Дотоодын цэрэгт хугацаат цэргийн алба хаагч татахгүй байх шийдвэр гаргаж, өнгөрсөн онд гаргасан Засгийн газрын тогтоолд өөрчлөлт орууллаа.

Ингэснээр 5 дугаар сард улсын хэмжээнд цэрэг татлага явагдахгүй. Харин Хилийн цэрэг болон Зэвсэгт хүчний 032 дугаар ангид 2020 оны нэгдүгээр ээлжээр татагдаж алба хаасан хугацаат цэргүүд 2021 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн халагдах юм.

## ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭНД СОРЬЦ ЦУГЛУУЛАХ ТҮР ЦЭГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ

Улсын хэмжээнд цар тахал хүрээгээ тэлж, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний дунд коронавируст халдварын тохиолдол бүртгэгдэх болсонтой холбогдуулан Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны А/58 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний дунд коронавируст халдварын тархалтыг илрүүлэх тандалтын шинжилгээ авах бүлэг, А/111 дүгээр тушаалаар Улаанбаатар цэргийн хүрээний бие бүрэлдэхүүнийг коронавирусийн эсрэг дархлаажуулалтад хамруулах 1 түр цэг, 4 хөдөлгөөнт бүлгийг тус тус томилж, хэрэгжилтийг ханган ажиллалаа.

### ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТАЛААР

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг ДЭМБ-ын зөвшөөрөл бүхий Энэтхэг Улсад үйлдвэрлэсэн “Ковишил” вакцинаар дархлаажуулах Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын өгсөн үүргийн дагуу Эрүүл мэндийн хэлтэс нь ХӨСҮТ-д 17500 хүн-тун вакцины захиалга хүргүүлж, 10150 хүн-тун хүлээн авч, Улаанбаатар цэргийн хүрээний анги, байгууллагын алба хаагчдыг 2021 оны 3 дугаар сарын 10-16-нд, стратегийн ач холбогдол бүхий Зэвсэгт хүчний Төмөр замын бүтээн байгуулалтад оролцож буй алба хаагчид болон Зэвсэгт хүчний 336, 167 дугаар ангиудын алба хаагчдыг 2021 оны 3 дугаар сарын 17-20-нд, нийт 10130 хүнийг дархлаажуулалтын эхний тунд хамруулсан.

БНХАУ-д үйлдвэрлэсэн “Веросел” вакцинаас нийт 130 хүн-тун ХӨСҮТ-өөс хүлээн авч, БНХАУ-ын Элчин сайдын яамын 30 алба хаагч, Ахмадын хорооны 100 ахмадыг тус тус хамруулсан байна.

Батлан хамгаалах сайдын өгсөн үүрэг, Уул уурхайн хүнд үйлдвэрийн яамны хүсэлтийн дагуу Зэвсэгт хүчний Жанжин штаб нь вакцинжуулалтын хөдөлгөөнт 4 бүлгийг ажиллуулан Өмнөд бүсийн уул уурхайн 84 аж ахуйн нэгж байгууллагын 10200 ажилчдын дархлаажуулалтыг БНХАУ-д үйлдвэрлэсэн “Веросил” вакцины эхний тунд хамруулах ажлыг 2021 оны 3 дугаар сарын 20-28-нд зохион байгуулж, 9068 уул уурхайн ажилчдыг дархлаажуулсан.

Өнөөдрийн байдлаар зүүн болон баруун бүсийн 5454 уул уурхайн ажилчдыг “Веросел” вакцинаар дархлаажуулах төлөвлөлтийг хийж, Дорнод, Сүхбаатарын чиглэлд 2 хөдөлгөөнт бүлгийг томилон ажиллуулах бэлтгэл ажлыг хангаад байна.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг “Ковишел” вакцины хоёрдугаар тунгаар дархлаажуулах ажлыг 2021 оны 5 дугаар сарын 8-ны өдрөөс, БНХАУ-ын Элчин сайдын яам, Ахмадын хорооны болон Уул уурхайн ажилчдын давтан тунг 2021 оны 4 дүгээр сарын 18-ны өдрөөс эхэллээ.

Зэвсэгт хүчний хөдөө орон нутгийн 7000 гаруй алба хаагчийг Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын өгсөн чиглэлийн дагуу ДЭМБ-ын яаралтай горимоор хэрэглэх түр зөвшөөрөл авсан “Астразеника” вакцинд 5 дугаар сард хамруулахаар төлөвлөн ажиллаж байна. Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар ХӨСҮТ-д “Астразеника” вакцины нийлүүлэлт хийгдэж, Засгийн газар, УОК, Эрүүл мэндийн яамны түвшинд судлагдаж байна.

### ШИНЖИЛГЭЭНД СОРЬЦ ЦУГЛУУЛАХ ТҮР

### ЦЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний дунд коронавируст халдварын тандалтын шинжилгээг 2020 оны 12 дугаар сарын 14-ны өдрөөс эхлэн өнөөдрийг хүртэл 85 нэгтгэл, анги, байгууллагын 12881 хүнд хийгээд байна. Үүнээс ПГУ/PCR/ шинжилгээнд 12005 хүнээс сорьц цуглуулж, ХӨСҮТ-ийн Вируст судлалын лабораторийн шинжилгээнд илгээж, 93 батлагдсан тохиолдлыг илрүүлж, ойрын болон дам хавьталыг тодорхойлон ажиллаж, тусгаарлан сэргийлэлтийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Мөн 876 хүнд түргэвчилсэн шинжилгээ хийжээ. Шинжилгээнд сорьц цуглуулах түр цэгийг ЗХНЛ, “Алдар” спорт хорооны хуучин заалыг түшиглэн байгуулж, өдөрт дунджаар 150-450 орчим бие бүрэлдэхүүнээс шинжилгээ авчээ.

Өнөөдрийн байдлаар Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллагын дунд голомтлон гарч буй халдварыг хумих зорилгоор Эрүүл мэндийн хэлтэс ХӨСҮТ болон ЗӨСҮТ-тэй харилцан тохиролцож, зөвхөн дам болон ойрын хавьталд шинжилгээ хийн, 1270 дам болон ойрын хавьтлаас сорьц цуглуулан ажиллаж байна. Иймд цаашид улсын хэмжээнд бүх нийтийн дархлаажуулалтыг дуусгавар болох хүртэл хугацаанд бие бүрэлдэхүүнээс хоногт 50-100 сорьц цуглуулах ажлыг үргэлжлүүлэх хэрэгцээ шаардлага байгаагаа ХӨСҮТ-д илэрхийлсэн боловч асуудлаа шийдвэрлүүлж чадаагүй байна.

### ЗХЖШ-ЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ХЭЛТЭС

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
6	-3
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
34	23
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
26	14

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2.845.00	2.856.00
EUR	3.430.00	3.490.00
CNY	438.80	442.20
RUB	37.80	39.40
JPY	25.98	26.49
KRW	2.48	2.62

## ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 19  
2021.04.30.  
/БААСАН ГАРАГ/

**ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ  
САРЫН ТАВАН ШАР  
БИЧ ӨДӨР**

Үс засуулбал:  
Сайн нөхөртэй нөхөрлөнө.

Наран ургах, шингэх:  
05.36-20.03

Барилдлага:  
Шид

Шүтэн барилдлага:  
Хуран үйлдэхүй

Суудал:  
Гал.

Аргын тооллын 4 дүгээр сарын 30, Сугар гараг. Билгийн тооллын 19, Эрхтний тэнгэрт одтой, шар бич өдөр. Өдрийн наран 5 цаг 36 минутад мандан, 20 цаг 30 минутад жаргана. Тухайн өдөр хулгаана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвших, сүм дуганыг сэргээх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, гөлөг тэмжээхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгаана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одоогод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал "Сайн нөхөртэй учирна" хэмээх сайн.

## ЦДБЭЧ-ЫН УДИРДЛАГУУД ГАВЬЯАТУУДДАА ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ

Дэлхийн бүжгийн өдөр буюу 4 дүгээр сарын сарын 29-нд Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгад бие даасан бүжиг анги бий болж, цэргийн бүжгийн урлагийг хөгжүүлж ирсний 80 жилийн ой тохиолоо. Энэхүү түүхэн тэмдэглэлт өдрийг тохиолдуулан ЦДБЭЧ-ын дарга, хурандаа Г.Золзаяа, Захиргаа үзвэр үйлчилгээний хэлтсийн дарга, дэд хурандаа А.Дондов, Сургалт, соёл хүмүүжил, маркетингийн албаны дарга, дэд хурандаа Р.Өнөржаргал нар одоо ажиллаж хөдөлмөрлөж буй тус чуулгын гавьяат цолтон уран бүтээлчид болох гоцлол бүжигчин, МУГЖ ахлах ахлагч А.Бямбатөгс, гоцлол дуучин, МУГЖ, ахлах ахлагч Б.Батбаатар



нарыг хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ. Гоцлол бүжигчин А.Бямбатөгс 2017 онд чуулгынхаа 85 жилийн ойгоор төрсөн гавьяат цолтон бол гоцлол дуучин Б.Батбаатар нь 2018 онд Ерөнхийлөгчийн зарлигаар тус чуулгаас нэг дор төрсөн 3 гавьяатын нэг юм. МУГЖ Б.Батбаатар, МУГЖ А.Бямбатөгс нарын олон арван бүтээл нь чуулгын урын санг баяжуулж ирсэн бөгөөд тэд гадаад дотоодын мэргэжлийн урлагийн уралдаан тэмцээнд улс эх орон, Батлан хамгаалах салбар, урлагийн байгууллагуудыг төлөөлөн оролцож, тэргүүн байрын шагналуудыг эзэлж ирсэн бахархлын эзэд юм.

Тэд төрийн хүндэтгэлийн болон ойн баяр ёслол, соёлын арга хэмжээнүүдэд манлайлан оролцож, гадаадын зочид төлөөлөгчид, ард иргэд, цэрэг дайчдад соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, Батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг тайз дэлгэцээр дамжуулан сурталчилж, эх оронч үзлийг төлөвшүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буй гавьяатууд билээ. Чуулгын удирдлагаас гавьяатууддаа энэхүү түүхэн өдрүүдийг өөрсдийн бүтээлээрээ чимж, түмэн олны бахархлыг хүлээж яваад нь баяр хүргэж, хамт олноо манлайлан ажиллах их үйлсэд нь нийт бие бүрэлдэхүүний өмнөөс амжилт хүсэв.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
33.608+1015	18.719	102/8

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
1981 (23)	292	1666

## КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД


Тохиолдол	Нийт: 148,329,348
Эдгэрсэн	Нийт: 128,255,446
Нас барсан	Нийт: 3,128,962

УЛААНБААТАР	30,172	БАЙРШИЛ
АРХАНГАЙ	299	228
БАЯН-ӨЛГИЙ	2	2
Баянхонгор	84	386
Булган	91	13
Говь-Алтай	33	255
Говьсүмбэр	43	166
Дархан-Уул	586	11
Дорноговь	59	0
Дорнод	35	582
Дундговь	54	4
Өвөрзөгдсөн	458	769
Өвөрхангай	1	36
Сүхбаатар	1	32
Төв	1	0
Увс	1	0
Ховд	1	222
Хөвсгөл	1	3
Хэнтий	1	67
Хэнтий	1	57
Хэнтий	1	0
Тусгаарлалт хяналтад	139	0

2021.04.29

ЦАХИМ ШУУДАНД

РОТ БҮР УРИАЛГА ГАРГАНА



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

ЗХЖШ-аас гаргасан хөтөлбөрийн дагуу төрийн цэргийн болон хууль,

иргэний байгууллагуудтай хамтран рот (батареи), салааны захирагч нарт явуулах "Зөв төлөвшил, зөв хүмүүжил" зөвлөгөөний эхний шатыг хоёр өдрийн турш

цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан цахимаар зохион явуулж байна. Нэгтгэлийн салаа, салбарын офицеруудын цэргийн сургалт бэлтгэлийг төлөвлөх, удирдан явуулах, заах арга зүйг сайжруулах, дүрмийн дагуу цэргийн алба хаагчидтай харьцах, өөрийн удирдлагад байгаа захирагдагчдаа сурган хүмүүжүүлэх, эх оронч үндэсний үзэлтэй зөв иргэн хүн болгон төлөвшүүлэхэд энэхүү зөвлөгөөний зорилго оршиж байгаа юм. Зөвлөгөөнөөр салаа, салбарын офицер, ахлагч нар цаашид хэрхэн ажиллах, ажлын арга барил, зорилго, зорилтоо тодорхойлохоос гадна рот /батареи/ тус бүрээр уриалга гаргуулж, хэлэлцүүлгийг зохион байгуулж, мөн хоёрдугаар шатны зөвлөгөөнд оролцох рот (батареи), салааны захирагч нарыг шалгаруулах юм.

ЗӨВЛӨГӨӨНИЙГ ТӨРИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГУУДАЙ ХАМТРАН ЯВУУЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний 123 дугаар анги

Батлан хамгаалахын сайдын өгсөн үүрэг, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын албан даалгаврын хүрээнд рот /батареи/, салааны захирагч нарын зөвлөгөөнийг "Зөв төлөвшил, зөв хүмүүжил" сэдвийн хүрээнд хоёр дахь өдрөө явуулж байна. Зөвлөгөөний эхэнд тус ангийн захирагч, хурандаа Х.Энхболд Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа сэдвээр мэдээлэл өгсний дараа "Удирдагчийн ёс зүй, удирдах арга ухаан" сэдвээр сургалт хийв. Мөн Ховд аймаг дахь төрийн цэргийн байгууллагын мэргэжилтнүүдтэй хамтран хүний эрх, хууль эрх зүйн мэдээлэл болон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх цахим сургалтыг явуулж байгаа юм.

Ахмад Э.ЗОЛЗАЯА



ХУРАНДАА НАР УРИАЛЖ БАЙНА



Хурандаа С.Эрдэнэбаатар, Ж.Цэрэнчимэд, С.Түвшинбаяр, бэлтгэл хурандаа Ө.Батмөнх, Б.Мягмар, Б.Алтангэрэл, С.Эрдэнэтөгс, Г.Сүхбаатар, Д.Батбаатар, М.Буянжаргал зэрэг хурандаа нар нэгдэн спортоор эрчимтэй хичээллэн бусдыгаа уриалан дуудаж байгааг сошиалаар уншигч та багагүй харсан байх. Тэд өдөр бүр өглөө эрт цуглан алхалт хийж, цэргийн хүний хийж биеүүлэх ёстой биеийн тамирын дасгал, нормативыг биелүүлдэг бөгөөд сагсан бөмбөг, хөл бөмбөг, газрын теннисээр хичээллэж, уралдаан тэмцээнүүдэд амжилттай оролцдог аж. Мөн хажуугаар нь дасгал хийдэг газруудынхаа хогийг түүж цэвэрлэдэг

төдийгүй ажил, амьдралын туршлагаа хуваалцаж, зөвлөлдөж, туслаж, нэгнийхээ хоббиг дэмжиж цуглуулгыг нь баяжуулахад идэвхийлэн оролцдог гээд тэднээс суралцах, хэрэгжүүлэх зүйл чамгүй бий. Тэд мөн Энхийг сахиулагчдын цогцолборын тохижилтод хувь нэмрээ оруулах зорилготой байгаа аж. Өнгөрсөн 9 дүгээр сард цөөхүүлээ санаа нийлэн ууланд алхаж эхэлснээс хойш эдүгээ дэслэгч, ахлагч дэслэгч, ахмад болон ахлах офицерууд нэгдэж хүрээгээ тэлжээ. Хурандаа Ө.Батмөнх ахлагчтай "Хурандаа нарын баг"-ийнхан үлгэрлэн манлайлж, өөртөө цаг гарган спортоор хичээллэж, эрүүл идэвхтэй амьдрахыг уриалж байна.



ХҮНИЙ ОЮУН УХААНЫГ ХЭМЖИХ 10 КОЭФФИЦИЕНТ

Оюун ухааныг хэмжих болсон түүх 1869 оноос эхтэй. Френсис Гальтон, өөрийн үеэл ах Чарльз Дарвины хийсэн ажлын үр дүнг хараад төрсөн сэтгэгдлээрээ "Авьяасыг өвөлж авах нь" бүтээлээ хэвлүүлжээ. Хүмүүсийн хувийн онцлогийг тайлбарлахыг оролдохдоо тэрээр сэтгэл судлал ба антропологиуд удамшлын тухай ойлголтыг анх оруулсан юм. Гальтон нэртэй хүмүүсийн намтрыг судалж үзэхдээ, тэдний садан төрлийн холбоо хэр ойр болохыг олж тогтоохыг оролджээ. Эдгээр судалгаанаас тэр оюун ухааны өндөр чадвар нь олон талаараа удамшлын хүчин зүйлээс ихээхэн шалтгаалдаг. Гэхдээ тухайн хүн түүнийгээ илрүүлж, дэлгэн гаргаж чадах эсэхэд өөр олон хүчин зүйл нөлөөлдөг гэсэн дүгнэлт хийсэн байна. Хүний бие бялдрын болон сэтгэл зүйн шинж чанарууд хоорондоо холбоотой гэж үзсэний үндсэн дээр тэдгээрийг тодорхойлох статистик аргачлал зохиожээ.

**1. IQ-INTELLIGENCE QUOTIENT.** Танин мэдэхүйн оюун ухааныг хэмжих суурь ойлголт IQ нь тунгаан бодох, асуудлыг шийдвэрлэх, шинэ материал судлах чадварыг илэрхийлнэ. Өндөр хөгжилтэй орнуудын алдартай корпорациуд ажилтан авахдаа IQ-г нь шалгаж авдаг. Тухайлбал, програм хангамжийн салбарт тэргүүлж буй "Microsoft" корпораци 120-иос дээш IQ-тай программистыг ажилд авдаг байна. АНУ тэргүүтэй өндөр хөгжсөн орны нэр хүндтэй их сургуулиудад элсэх үндсэн нөхцөл нь оюуны чадварын ерөнхий тестийн (SAT, GRE) босго оноог давах буюу IQ өндөр байх явдал юм. Эрдэмтдийн судалгааны үр дүнд хүн төрөлхтний 0.4 хувь нь 140-өөс дээш IQ-тай буюу сод ухаантай, 0.4 хувь нь

сэтгэлгээг байнга урамшуулж, хөхүүлэн дэмжиж хөгжүүлж байх ёстой.

**5. SQ-SPIRITUAL QUOTIENT** буюу оюун санааны хүч чадлын илтгэцүүр нь биеэ дайчилж зорьсондоо хүрэх сэтгэлийн зориг тэвчээрийг харуулдаг. SQ нь өөрийн мэдлэг туршлагаа мэргэн ухаан, азтай агшин болгон хувиргах сэтгэхүйн чадвар юм.

**6. DQ-DEVELOPMENT QUOTIENT.** Өөрийн бие бялдрын байдал онцлогийг тодорхой мэдэж, алхам алхмаар биеэ хөгжүүлэн зорьсон зорилгодоо хүрч амжилт гаргах чадварын илтгэцүүр. DQ өндөртэй хүн өөрийн биеийн онцлог ба чадварыг зөв үнэлж, тогтвортой, системтэй



70-аас доош IQ-тэй буюу оюун ухааны хомсдолтой бөгөөд бусад 99.2 хувь нь оюуны чадварын хувьд ерөнхийдөө ижил байдгийг тогтоожээ.

хичээллэх чадвартай болдог. Ялангуяа урлаг спортын амжилт DQ-гээр дамжин илэрдэг.

**2. EQ-EMOTIONAL QUOTIENT** нь сэтгэл хөдлөл, харилцааны чадварын илтгэцүүр. Зах зээлийн нийгэм нь хүний бүх талын хөгжил, ялангуяа харилцах урлагийг ихээхэн үнэлдгийг бид мэдэрч эхэлж байна. Нийгмийн харилцааны оюун ухаан гэгддэг EQ нь өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, сэтгэл хөдлөлөө зохистой илэрхийлэх, өөрийгөө урамшуулах, тэвчээртэй байх, үргэлж сэтгэл өөдрөг явах зэрэг цогц чадварыг харуулдаг. EQ өндөртэй хүн өөрийнхөө сэтгэлийн дотоод хөдлөлд авталгүй биеэ барих чадвар эзэмшсэн байх бөгөөд орчинтойгоо зохицон, ажлаа амжилттай явуулж чаддаг.

**7. MQ-MORAL QUOTIENT.** Хүний нийгэмд өөрийгөө зохицуулж, үйлийнхээ хэм хэмжээг тогтоох чадвар. MQ өндөртэй хүн сайн мууг ялгах, бусдыг чин сэтгэлээсээ хайрлах чадвартай.

**3. AQ-ADVERSITY QUOTIENT.** Бэрхшээлийг даван туулах шаргуу зүтгэл, өөдрөг санаа, зориг эрмэлзлийг харуулдаг илтгэцүүр бол AQ. AQ муутай хүн аливаа гэнэтийн явдалд амархан цочирдож, сэтгэлийн хөдөлгөөнд автдаг бол өндөр AQ-тай хүн ямар ч хүнд нөхцлийг сэтгэлийн хатаар давж лидер болдог. Харвардын их сургууль бизнесийн ангийн оюутныхаа AQ-г хөгжүүлэхэд маш их анхаардаг.

**8. NQ-NET QUOTIENT.** Мэдээллийн сүлжээнд ажиллах чадварыг илэрхийлнэ. NQ бол орчин үед моодонд орж байгаа нэр томьёо бөгөөд залуу үеийг боловсруулах практик модель. NQ нь мэдээлэлтэй харьцах чадвар болон мэдээллийн орчинд өөрийгөө захирах чадварыг хүүхдэд эзэмшүүлдэг.

**4. CQ-CREATIVE QUOTIENT.** Бүтээлч чадварын илтгэцүүр нь өөрийн бүтээх чадвараа зөв танин мэдэж, шинийг сэтгэн бодож, бүтээх чадвараа байнга дээшлүүлэх чадварыг харуулдаг. Зохион бүтээгчид, шинийг эрэлхийлэгчид бүгд багаасаа CQ өндөртэй байжээ. Хүний хамгийн их бүтээлч сэтгэлгээтэй үе бол хүүхэд нас. Иймд та хүүхдийнхээ бүтээлч

**9. BQ-BONDING QUOTIENT.** Эцэг эх үр хүүхдийн дотно харилцааны үзүүлэлт. Ялангуяа 0-7 насны хүүхэдтэй эцэг эхчүүд BQ өндөртэй байх хэрэгтэй. BQ өндөртэй эцэг эхчүүд өөрийн үр хүүхдэд онцгой халамж тавьдаг, хүүхдийнхээ онцлогийг мэдэх чадварыг эзэмшсэн байдаг. BQ өндөртэй хүүхэд өөртөө итгэлтэй сэтгэл хангалуун байх бөгөөд эцэг эхдээ улам дотносоноор EQ нь бүр ч өснө. Улмаар хүүхдийн сэтгэл санаа тайван болж гадаад ертөнцийг сонирхсоноор IQ нэмэгдэх бол гэр бүлийн уур амьсгал халуун дулаан болсноор MQ өснө.

**10. FQ-FINANCIAL QUOTIENT.** Хөрөнгө мөнгийг оновчтой захирах чадварыг илтгэх илтгэцүүр. Өндөр хөгжилтэй орны иргэд хүүхдийнхээ FQ-г дээшлүүлэхийн тулд ирээдүйн саянуудын клубт хичээллүүлж, Монопол (саятан) зэрэг тоглоомыг багаас нь тоглуулдаг байна.